| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                    | <b><u>45,876,902.58</u></b>   | <b><u>(32,995,942.98)</u></b> |
| <b>5</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                           | <b>26,359,000.00</b>          | <b>-</b>                      |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>26,359,000.00</b>          | <b>-</b>                      |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>   | <b>26,359,000.00</b>          | <b>-</b>                      |
| 225106      | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                             | 26,359,000.00                 | -                             |
| <b>6</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | <b><u>(26,359,000.00)</u></b> | <b>=</b>                      |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                           | <b>19,517,902.58</b>          | <b>(32,995,942.98)</b>        |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                    | <b>638,721.65</b>             | <b>35,267,124.23</b>          |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                   | <b>35,267,124.23</b>          | <b>2,271,181.25</b>           |

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт                            | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|-------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 617,572,175.10                  | 148,825,592.14        | 136,513,336.54    | 902,911,103.78                          |

|     |                                       |                |                |                |                |
|-----|---------------------------------------|----------------|----------------|----------------|----------------|
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | 617,572,175.10 | 148,825,592.14 | 136,513,336.54 | 902,911,103.78 |
| C07 | Тайлант үеийн үр дүн                  | -              | -              | 20,761,553.38  | 20,761,553.38  |
| C08 | 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 617,572,175.10 | 148,825,592.14 | 157,274,889.92 | 923,672,657.16 |
| D01 | 2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл   | 617,572,175.10 | 148,825,592.14 | 157,274,889.92 | 923,672,657.16 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | 617,572,175.10 | 148,825,592.14 | 157,274,889.92 | 923,672,657.16 |
| D08 | Тайлант үеийн үр дүн                  | -              | -              | 40,851,966.67  | 40,851,966.67  |
| D09 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 617,572,175.10 | 148,825,592.14 | 198,126,856.59 | 964,524,623.83 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт  | Тайлант оны           |                |
|-----------------------|---|-----------------------|----------------|
|                       |   | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      |
| <b>2</b>              | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                  | 829,343,300.00        | 742,675,613.41 |
| <b>21</b>             | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                      | 829,343,300.00        | 742,675,613.41 |
| <b>210</b>            | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                    | 829,343,300.00        | 742,675,613.41 |
| <b>2101</b>           | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                  | 561,535,600.00        | 509,046,357.00 |
| 210101                | Үндсэн цалин  | 383,357,600.00        | 316,799,707.92 |
| 210102                | Нэмэгдэл  | 121,143,000.00        | 139,232,900.18 |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт                                     | 10,235,000.00         | 5,525,094.08   |
| 210104                | Урамшуулал  | 46,800,000.00         | 47,488,654.82  |
| <b>2102</b>           | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>     | 70,192,000.00         | 63,993,726.76  |
| 210201                | Тэтгэврийн даатгал  | 47,730,600.00         | 44,556,692.35  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал  | 5,615,400.00          | 5,098,891.07   |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал   | 4,492,300.00          | 4,065,912.83   |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                      | 1,123,000.00          | 933,839.17     |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                     | 11,230,700.00         | 9,338,391.34   |
| <b>2103</b>           | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>          | 45,707,900.00         | 41,757,035.65  |
| 210301                | Гэрэл, цахилгаан  | 6,151,900.00          | 2,632,235.65   |
| 210302                | Түлш, халаалт   | 39,121,600.00         | 39,124,800.00  |
| 210303                | Цэвэр, бохир ус   | 434,400.00            | -              |
| <b>2104</b>           | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                   | 30,181,300.00         | 27,546,170.00  |
| 210401                | Бичиг хэрэг   | 3,599,700.00          | 3,119,500.00   |
| 210402                | Тээвэр, шатахуун  | 22,149,700.00         | 20,231,170.00  |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                        | 1,231,900.00          | 1,272,000.00   |
| 210405                | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,300,000.00          | 1,199,000.00   |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс               | 1,900,000.00          | 1,724,500.00   |
| <b>2105</b>           | <b>Нормативт зардал</b>                                   | 91,297,700.00         | 78,458,414.00  |
| 210501                | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                           | 75,556,000.00         | 65,803,514.00  |
| 210502                | Хоол, хүнс  | 13,241,700.00         | 10,194,900.00  |
| 210503                | Нормын хувцас, зөөлөн эдлэл                               | 2,500,000.00          | 2,460,000.00   |
| <b>2106</b>           | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                  | 10,837,600.00         | 7,787,500.00   |

|             |   |               |               |
|-------------|---|---------------|---------------|
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   | 4,000,000.00  | 1,854,500.00  |
| 210604      | Урсгал засвар   | 6,837,600.00  | 5,933,000.00  |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                   | 4,440,000.00  | 3,199,000.00  |
| 210702      | Дотоод албан томилолт   | 4,440,000.00  | 3,199,000.00  |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | 3,608,700.00  | 2,585,060.00  |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                        | 1,080,000.00  | 1,080,000.00  |
| 210803      | Даатгалын үйлчилгээ   | 275,000.00    | 238,500.00    |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                      | 140,000.00    | 140,000.00    |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                   | 99,000.00     | 40,300.00     |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                 | 734,700.00    | 728,000.00    |
| 210807      | Газрын төлбөр   | 140,000.00    | -             |
| 210808      | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж              | 60,000.00     | 1,800.00      |
| 210809      | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх                          | 1,080,000.00  | 356,460.00    |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                          | 11,542,500.00 | 8,302,350.00  |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                 | 11,542,500.00 | 8,302,350.00  |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                           | 83,312,700.00 | 48,045,300.00 |
| <b>1320</b> | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                           | 83,312,700.00 | 48,045,300.00 |
| 122005      | Орон нутгийн төсвөөс  | 48,045,500.00 | 48,045,300.00 |
| 132004      | Оны эхний үлдэгдэлээс санхүүжих /орон нутаг/                    | 35,267,200.00 | -             |
| <b>4</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>         | -             | 35,267,124.23 |
| <b>5</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>        | -             | 907,926.00    |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа:

Түдэвтэй сумын Эрүүл мэндийн төв нь Дотор, төрөх эмэгтэйчүүд, хүүхэд, мэс засал, шүд, уламжлалтын тасаг гэсэн зохион байгуулалтайгаар эмнэлгийн үйл ажиллагаа явуулдаг

**Эрхэм зорилт:** Бат бэх баазтай, ард иргэдэд эмчилгээ үйлчилгээ, сургалт сурталчилгаа явуулдаг, үйлчлүүлэгчиддээ хандсан орчин үеийн соёлтой сумын эмнэлэг болно.

Чиг үүрэг: Эрүүл мэндийн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Сумын ЭМТ-ийн дэргэд дотоод аудитын чиг үүрэг бүхий аудитор, дотоод хяналтын нэгж байхгүй байна. Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түдэвтэй сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түдэвтэй сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,405.96 мянган төгрөгөөр буюу 0,45 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                                     | /мянган төгрөгөөр/ |                   |                 |
|--|--------------------|-------------------|-----------------|
|  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл   | Өөрчлөлт        |
| Б  | 1.00               | 2.00              | 3=2-1           |
| Авлага                                       |                    | 24,546.93         | (24,546.93)     |
| Бараа материал                               | 84,255.30          | 39,679.60         | 44,575.70       |
| Үндсэн хөрөнгө                               | 849,594.90         | 898,163.60        | (48,568.70)     |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>969,117.29</b>  | <b>964,711.33</b> | <b>4,405.96</b> |
| Өр төлбөр                                    | 454,444.63         | 136.70            | 454,307.93      |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 923,672.66         | 964,524.62        | (40,851.97)     |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>969,117.29</b>  | <b>964,711.33</b> | <b>4,405.96</b> |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### Тайланд онд

Бараа материал эхний үлдэгдэл 84,255.3 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 119,492.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй 8,360.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулсан 132,821.6 мянган төгрөг, акталсан бараа материал байхгүй бараа материалын эцсийн үлдэгдэл 898,163.60 мянган төгрөг болж өмнөх оноос 3,993.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр хөрөнгө худалдан аваагүй, хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй 36,624.7 мянган төгрөг, бусад байгууллагаас шилжүүлэн авсан 43,000.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, 7,250.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна. Жилийн эцэст 937,843.20 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 88,571.0 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 40,851.97 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 664,681.8 мянга, нэмэлт санхүүжилтээс 48,045.3 мянган төгрөг нийт зарлагыг 781,297.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 664,681.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас бүрдүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| Хөтөлбөр, арга хэмжээ                       | Үзүүлэлт                              | Төлөвлөгөө        | Гүйцэтгэл        | Зөрүү            | Биелэлт     |
|---|---------------------------------------|-------------------|------------------|------------------|-------------|
| <b>Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих</b> |                                       |                   |                  |                  |             |
| <b>71602</b>                                | <b>Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>    |                   |                  |                  |             |
| 80302                                       | Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон | 370,846.20        | 371,457.20       | <b>611.00</b>    | <b>100%</b> |
| 81603                                       | Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ   | 375,184.40        | 327,127.80       | <b>20,946.50</b> | <b>94%</b>  |
| 83603                                       | Нэмэлт дээд шатны төсвөөс хувиарилсан | 35,267.20         | 35,267.00        | <b>31.10</b>     | <b>100%</b> |
| <b>НИЙТ</b>                                 |                                       | <b>781,297.80</b> | <b>664,681.8</b> |                  | <b>89%</b>  |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй байдаг ба нэмэлт санхүүжилтээр 1 хөтөлбөрийн хүрээнд 1 арга хэмжээг санхүүжүүлж 48,045.5 мянган төгрөг тогтмол зардалд зарцуулсан байна.

#### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

#### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|-----------------------------|-----------|-----------|
| 1 | Шууд худалдан авалт                             | Өвчтөний хоолны материал    | 13,241.70 | 10,194.90 |
| 2 | ЭМГ тендер. Гэрээ                               | Эмийн зардал                | 75,556.00 | 65,803.50 |
| 3 | Шууд гэрээ байгуулах                            | Тээвэр шатахуун             | 22,149.70 | 20,181.20 |
| 4 | Шууд гэрээ байгуулах                            | Шуудан ходбоо, интернет     | 1,231.90  | 1,272.00  |

|   |                      |                                 |                   |                   |
|---|----------------------|---------------------------------|-------------------|-------------------|
| 5 | Шууд худалдан авалт  | бичиг хэрэг                     | 3,599.70          | 3,119.50          |
|   | Шууд худалдан авалт  | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,542.50         | 8,302.30          |
| 5 | Шууд гэрээ байгуулах | Түлш халаалт                    | 39,121.60         | 39,124.80         |
| 6 | Шууд гэрээ байгуулах | Гэрэл цахилгаан                 | 6,151.90          | 2,632.20          |
| 7 | Шууд гэрээ байгуулах | Цэвэр, бохир ус                 | 434.40            | -                 |
| 8 | Шууд худалдан авалт  | Урсгал засвар                   | 2,337.60          | 2,333.00          |
|   | <b>ДҮН</b>           |                                 | <b>175,367.00</b> | <b>152,963.40</b> |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түдэвтэй сумын эрүүл мэндийн төв 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Уранбаяр гүйцэтгэж, хяналтыг Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал Х.Диймаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Түдэвтэй сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 13 -ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 352,400.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 5,286.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,964.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 29 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Түдэвтэй сумын Эрүүл мэндийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж гүйцэтгээгүй байна.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,398.0 төгрөгийн 2 зөвлөмжийг хугацаанд нь барагдуулж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт |         | Биелэлт |         |      |
|----------|------------------------|---------|---------|---------|------|
|          | Тоо                    | Дүн     | Тоо     | Дүн     | Хувь |
| Зөвлөмж  | 2                      | 5,398.0 | 2       | 5,398.0 | 100  |
| Нийт дүн | 2                      | 5,398.0 | 2       | 5,398.0 | 100  |

**Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудлыг тодохойлоогүй байна.

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

**5.1 Залруулга байхгүй**

**5.2 Албан шаардлага хүргүүлээгүй**

**5.3 Төлбөрийн акт тогтоогоогүй**

**5.4 Зөвлөмж хүргүүлээгүй**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил |     | /мянган төгрөгөөр/<br>Үүнээс |     |                 |     |         |     |                                      |     |   |     |  |
|--------------------|-------------|-----|------------------------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|-----|---|-----|--|
|                    |             |     | Төлбөрийн акт                |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |  |
|                    | Тоо         | Дүн | Тоо                          | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн | Тоо                                  | Дүн | Тоо   | Дүн |  |
| <b>Дүн</b>         |             |     |                              |     |                 |     |         |     |                                      |     |   |     |  |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2024-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР ОГНОО: 2024-02-22

АХЛАХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2024-02-22

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР

Г.УРАНБАЯР ОГНОО: 2024-02-22